



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/211

Чингис хот

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 16.2, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Жипэл” ХХК-ийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт орших “Саригийн хөндий” нэртэй 25.247 гектар талбай бүхий түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилээр сунгаж олгосой.

2. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан тухай ашигт малтмал, газрын тосны болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, тус аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Б.Дархантөр), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Б.Сүнгээ) нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011315